

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТУСГАЙ ТӨВ

**ТЭНЭМЭЛ, ОРОН ГЭРГҮЙ, АРХИНЫ ХАМААРАЛТАЙ ИРГЭДИЙН НИЙГЭМ - СЭТГЭЛ ЗҮЙН
БАЙДЛЫГ СУДАЛСАН СУДАЛГААНЫ ҮР ДҮН ДҮГНЭЛТ**

2021 оны 11 дүгээр сарын 30


Улаанбаатар хот

ЗОРИЛГО: Архи болон бусад шалтгаануудын улмаас орон гэргүй тэнэмэл амьдралаар амьдарч буй иргэдийн сэтгэл зүйн байдал түүнд нөлөөлж буй нийгмийн хүчин зүйлүүдийг судлан тэдэнтэй ажиллах арга зүйг боловсруулах

ХАМАРСАН ХҮРЭЭ: Түр хоноглох байраар үйлчлүүлж буй 23 -72 насны 112 иргэн үүнээс эрэгтэй 92, эмэгтэй 20 оролцсон бөгөөд Google Drive-аар ганцаарчилсан ярилцлагын аргаар судалгаагаа авлаа.

АСУУЛГЫН БҮТЭЦ: Сэтгэл зүйн байдал, амьдралын түүх, гэрлэлт, ажил эрхлэлт, сэтгэцийн эрүүл мэнд, мансууруулах бодисын хэрэглээ, биеийн эрүүл мэнд гэсэн 7 бүлэг 44 асуултаас бүтсэн.

Нэгдүгээр асуулт: Сэтгэл зүйн тулгамдаж буй асуудал ? , асуултын хариултын дүнг график 1-ээс харна уу.



- **Ганцаардал – 71,4%**
- Сэтгэлийн зовиур шаналгаа – 8,9%
- Нойргүйдэл – 9,8%
- Айдас – 1,7%
- Танин мэдэхүйн чадвар буурах – 2,6%
- Цөхрөл – 1,7%
- Буруутай мэдрэмж – 2,6%
- Бусдаас өөрийгөө тусгаарлах – 0,8%

1.1 Сэтгэл зүйн тулгамдсан асуудал хэзээнээс эхэлсэн бэ?, асуултын хариултыг тоон хувиар график 2-т харуулбал:




- ✚ 10 жилээс дээш – 78,5%
- ✚ 7 жил хүртэлх – 4,4%
- ✚ 5 жил хүртэлх – 2,6%
- ✚ 3 жил хүртэлх – 6,25%
- ✚ 1 жил хүртэлх – 8%



1.2 Сэтгэл зүйн асуудал тань юунаас болсон бэ? гэсэн асуултын үр дүнг график 3-т харуулъя:


- ✚ Гэр бүл салалт – 77%
- ✚ Бэлэвсэрсэн – 4%
- ✚ Орон гэргүй, архины хамааралтай – 7%
- ✚ Дотны хүнээ алдсан – 4%
- ✚ Эрүүл мэндийн байдал – 5%



Хоёрдугаар асуулт : Та хэний асрамжинд өссөн бэ? Гэсэн асуултын хариултыг график -4 харууллаа.

- ✚ Төрсөн аав, ээж – 46%
- ✚ Аав ээжийнхээ аль нэг – 19%
- ✚ Эмээ өвөө дээрээ – 19%
- ✚ Хамаатан садан -5%
- ✚ Үрчилж авсан аав, ээж – 5%
- ✚ Хойд аав, ээж – 2%
- ✚ Асрамжийн газар – 4%

Гуравдугаар асуулт: Хэдэн нас хүртлээ төрсөн аав ээж дээрээ амьдарсан бэ? Гэсэн асуултын үр дүнг график 5-аас харна уу.



Насанд хүртлээ – 60%
 Аав ээж дээрээ өсөөгүй – 29%
 11-16 нас – 6%
 6-10 нас – 2%
 0-5 нас – 3%

Дөрөвдүгээр асуулт: Та хэдэн нас хүртлээ хөхөө хөхсөн бэ? Гэсэн асуултын үр дүнг график 6-д харуулав.




0-2 нас хүртэл – 33%
 0-3 нас хүртэл – 11,6%
 3 дээш нас – 27,6%
 Угжаар – 14,2%
 Мэдэхгүй – 13,3%

Тавдугаар асуулт: Хэлд хөлд орохдоо таныг ямар нэгэн бэрхшээлтэй байсан гэж хэн нэгэн ярьж байсан уу?



Үгүй – 87%
 Тийм – 6%
 Мэдэхгүй – 7%

Зургаадугаар асуулт: Таны боловсролын байдал ? Гэсэн асуултын үр дүнг график- 8 харна уу.



- ✚ Дээд – 10%
- ✚ Тусгай дунд- 10%
- ✚ Бүрэн дунд - 36%
- ✚ Бага – 12%
- ✚ Бичиг үсэггүй – 5%

Долоодугаар асуулт : Хүүхэд насандаа сэтгэл зүйн цочролд өртсөн эсэх ? Гэсэн асуултын үр дүнг график-7 харна уу.




- ✚ Тийм – 56%
- ✚ Үгүй– 44%

Наймдугаар асуулт: Гэр бүлд нь сэтгэцийн өвчтэй хүн байсан уу ? асуултын үр дүнг график-10 харна уу.




- ✚ Мэдэхгүй - 12%
- ✚ Үгүй - 87%

Есдүгээр асуулт: Таны гэрлэлтийн байдал ? Асуултын үр дүнг график-11 харна уу?




- ✚ Салсан – 61,6%
- ✚ Гэрлэсэн – 9,8%
- ✚ Бэлэвсэрсэн – 19,6%
- ✚ Ганц бие – 8,9%

Аравдугаар асуулт: Хэрэв та гэрлэж байгаад салсан бол салсан шалтгаанаа ярина уу?




- ✚ Нууц амраг – 49,7%
- ✚ Архины асуудал – 27,5%
- ✚ Хадамын оролцоо- 4,3%%
- ✚ Тусдаа амьдарсан- 5,7%
- ✚ Гэр бүлийн хүчирхийлэл – 13%

10.1 асуулт : Ханьтайгаа хэдэн жил хамт амьдарсан бэ? асуултын үр дүнг график 13 харна уу.




- ✓ 1-5 жил – 27,5%
- ✓ 6-10 жил – 14,4%
- ✓ 11 дээш жил – 57,9%

10.2 асуулт: Та хэдэн хүүхэдтэй вэ? гэсэн асуултын хариултыг график -14 харна уу.




- ✓ 1-2 хүүхэдтэй – 88,4%
- ✓ 3-4 хүүхэдтэй – 8,6%
- ✓ 4 дээш хүүхэдтэй – 2,8%

10.3 асуулт: Хэн нь ихэвчлэн хүүхдээ хардаг байсан вэ? гэсэн асуултын хариултыг график 15 харна уу?



- ✚ Эхнэр : 53,3%
- ✚ Нөхөр – 17,5%
- ✚ Хамаатан садан – 15,7%
- ✚ Хамтдаа – 19,2%
- ✚ Цэцэрлэгээр – 7%


10.4 асуулт : Зөрчил зөрөлдөөн гарах үед ихэвчлэн яаж шийдвэрлэдэг вэ? асуултын хариултыг график -16 харна уу.




- ✚ Гэрээсээ гараад явчихдаг – 24%
- ✚ Дуугаа хураачихдаг – 40%
- ✚ Буулт хийдэг – 20%
- ✚ Ярилцах – 16%

10.5 асуулт: Хэн нь илүү шийдвэр гаргадаг байсан бэ? Гэсэн асуултын хариултыг график 17 харна уу.

✚ Эхнэр 54,1%
✚ Нөхөр 45,9%




10.6 асуулт: Хэн нь илүү орлого олдог байсан бэ? гэсэн асуултын хариултыг график 18 харна уу.



- ✓ Нөхөр – 80,8%
- ✓ Эхнэр – 19,2%

10.7 асуулт: Та гэр бүлээсээ салахыг зөвшөөрч байсан уу? Гэсэн асуултын хариултыг график 19 харна уу.



- ✓ Тийм- 45%
- ✓ Үгүй – 55%

Арванэгдүгээр асуулт: Та мэргэжилтэй юу? Гэсэн асуултын хариултыг график – 20 харна уу.




✚ Мэргэжилтэй – 70%
✚ Мэргэжилгүй – 30%

Арванхоёрдугаар асуулт: Та ажил эрхэлдэг үү? Гэсэн асуултын үр дүнг график 21 харна уу.




Арвангуравдугаар асуулт: Та хэдий хугацаанд ажил эрхлээгүй вэ? Гэсэн асуултын үр дүнг график 22 харна уу.



- ✓ 6 сар хүртэлх – 18%
- ✓ 1 жил хүртэлх – 22,8%
- ✓ 3 жил хүртэлх – 10,8%
- ✓ 5 жил хшртэлх – 19,2%
- ✓ 10 жил хүртэлх - 28,9%

Арвандөрөвдүгээр асуулт: Та ял эдэлж байсан уу? Гэсэн асуултын үр дүнг график 23 харна уу.




Арвантавдугаар асуулт: Тийм бол ял эдэлсэн хугацаа ? гэсэн асуултын хариултыг график 24 харна уу.



- ✚ 6 сарын баривчилгаа – 18,1%
- ✚ 1-3 жил – 36,3%
- ✚ 4-7 жил – 18,1%
- ✚ 8 жилээс дээш - 27,2%

Арванзургаадугаар асуулт: Ямар хэргээр хорих ангид ял эдэлсэн бэ? Гэсэн асуултын хариултыг график-25 харна уу.




- ✓ Хулгай дээрэм- 42,4%
- ✓ Танхай – 45,4%
- ✓ Хүн амь – 9%
- ✓ Хүчин – 3%

Арвандолдугаар асуулт: Танд үхлийн тухай бодол орж ирдэг үү? Гэсэн асуултын хариултыг график- 26 харна уу.



- ✓ Хааяа – 87%
- ✓ Байнга – 13%

Арваннаймдугаар асуулт: Та өөрийгөө гэмтээж байсан уу? Гэсэн асуултын хариултыг график- 27 харна уу.



Тийм – 13%
Үгүй – 87%

Арванесдүгээр асуулт: Гэр бүл найз нөхдийн чинь хүрээнд амиа хорлосон хүн байгаа юу? Гэсэн асуултын үр дүнг график 28 харна уу.




Тийм – 12%
Үгүй – 88%

Хорьдугаар асуулт: Та үр хөндөлт хийлгэж байсан уу? Гэсэн асуултын үр дүнг график 29 харна уу.




Тийм – 35%
Үгүй – 65%



Хориннэгдүгээр асуулт: Танд зулбалт тохиолдож байсан уу? Гэсэн асуултын үр дүнг график 30 харна уу.

Тийм – 45%
Үгүй – 55%

Хоринхоёрдугаар асуулт: Та тамхи татдаг уу? Өдөрт хэдэн ширхэг тамхи татдаг вэ? Гэсэн асуултын үр дүнг график 31 харна уу.




Хааяа нэг	– 15%
5-10 ширхэг	- 37%
11-20 ширхэг	- 9%
20-дээш	- 16%
Үгүй	- 23%

Хорингуравдугаар асуулт: Согтууруулах ундаа хэрэглэдэг үү? Гэсэн асуултын үр дүнг график 32 харна уу.




Тийм	– 89%
Үгүй	– 11%

Хориндөрөвдүгээр асуулт: Согтууруулах ундаа хэрэглэдэг давтамж ? Гэсэн асуултын үр дүнг график 33 харна уу.



Өдөр бүр	– 55%
3-7 хоногт	– 21%
14 хоногт	- 2%
Сард	- 6%
Баяр ёслолоор	– 16%

Хоринтавдугаар асуулт: Архи согтууруулах ундаа хэрэглэсэн хугацаа ? Гэсэн асуултын үр дүнг график 34 харна уу.



10 дээш жил	– 47%
5-10 жил	- 14%
2-5 жил	- 24%
0,5 – 2 жил	- 12%
0,5 жил хүртэл	- 3%

Хоринзургаадугаар асуулт: Архины эмчилгээнд хамрагдаж байсан уу? Гэсэн асуултын үр дүнг график 35 харна уу.


Архины эмчилгээнд хамрагдсан эсэх



Тийм – 44%
Үгүй - 56%

Хориндолоодугаар асуулт: Архины эмчилгээнд хэдэн удаа хамрагдсан бэ? Гэсэн асуултын үр дүнг график 36 харна уу.


Архины эмчилгээнд хэдэн удаа хамрагдсан эсэх



1 удаа – 68%
2 удаа – 9%
3 удаа – 12%
4 дээш – 11%


Хориннаймдугаар асуулт: Архи согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэж буй шалтгаан нөхцөл юу вэ? Гэсэн асуултын үр дүнг график 37 харна уу.

Архи ууж буй шалтгаан



Гэр бүл салалт – 69%
Уй гашуу – 21%
Найз нөхөд – 10%

Өөр төрлийн мансууруулах бодис хэрэглэдэг эсэх



Хоринесдүгээр асуулт: Та өөр бусад төрлийн мансууруулах бодийг хэрэглэж байсан уу? Гэсэн асуултын үр дүнг график 38 харна уу.

Үгүй – 98%
Хар тамхи - 1%
Цавуу үнэрлэх – 1%

Гучдугаар асуулт: Мөрийтэй тоглодог уу? Гэсэн асуултын үр дүнг график 39 харна уу.


Мөрийтэй тоглоом тоглодог эсэх



Үгүй – 91%
Хааяа – 9%

Гучиннэгдүгээр асуулт: Танд амьдрах орон гэр бий юу? Гэсэн асуултын үр дүнг график 40 харна уу.


Орон гэртэй эсэх



Орон гэртэй – 35%
Орон гэргүй – 65%

Гучинхоёрдугаар асуулт: Танд очих гэр бүл хамаатан садан байгаа юу? Гэсэн асуултын үр дүнг график 41 харна уу.


Хүлээж авах хамаатан садан байгаа эсэх



Байгаа – 43,7%
Байхгүй – 56,3 %

Гучингуравдугаар асуулт: Гадуур хэдэн жил амьдарч байна вэ? Гэсэн асуултын үр дүнг график 42 харна уу.

Гадуур амьдарсан хугацаа



0,5 жил хүртэл – 12%
0,5 – 2 жил – 18%
2-5 жил - 31%
5-10 жил - 8%
10 дээш жил – 31%

Гучиндөрөвдүгээр асуулт: Танд амьдрах орон гэр байгаа юу? Гэсэн асуултын үр дүнг график 43 харна уу.



Тийм – 10%
Үгүй – 90%

Гучинтавдугаар асуулт: Орон гэргүй болсон шалтгаан нөхцөл ? Гэсэн асуултын үр дүнг график 44 харна уу.



Зарсан – 20%
Гэр бүлдээ үлдээсэн – 77%
Шатсан – 3%

Гучинзургаадугаар асуулт: Гадуур амьдарч байгаа шалтгаан нөхцөл ? Гэсэн асуултын үр дүнг график 45 харна уу.




Гэр оронгүй – 28%
Архины хамаарал – 14%
Ганцаардал – 58%

Гучиндолоодугаар асуулт: Танд архаг хууч өвчин байгаа юу ? Гэсэн асуултын үр дүнг график 46 харна уу.



Тийм – 50%
Үгүй – 50%

Гучиннаймдугаар асуулт: Та сүрьеэ өвчин тусаж байсан уу ? Гэсэн асуултын үр дүнг график 47 харна уу.



Тийм- 23%
Үгүй - 77%

Гучинесдүгээр асуулт: Та ковид-19 халдвар авч байсан уу ? Гэсэн асуултын үр дүнг график 48 харна уу.



Тийм – 10%
Үгүй – 90%

Дөчдүгээр асуулт: Та аваар осолд өртөж байсан уу ? Гэсэн асуултын үр дүнг график 49 харна уу.



Авто – 41%
Үйлдвэр – 10%
Үгүй – 49%

Дөчиннэгдүгээр асуулт: Хөгжлийн бэрхшээлтэй эсэх ? Гэсэн асуултын үр дүнг график 50 харна уу.



Тийм – 22%
Үгүй - 78%

Дөчинхоёрдугаар асуулт: Яагаад хөгжлийн бэрхшээлтэй болсон бэ ? Гэсэн асуултын үр дүнг график 51 харна уу.




- ✚ Согтуудаа авто аварт орсон – 67%
- ✚ Согтуудаа хөлдөөсөн – 25%
- ✚ Төрөлхийн – 8%

Дөчингуравдугаар асуулт: Групп тэтгэмжинд хамрагддаг уу ? Гэсэн асуултын үр дүнг график 52 харна уу.



- ✚ Тийм – 12%
- ✚ Үгүй – 88%


Дөчиндөрөвдүгээр асуулт: Та хүсэл мөрөөдлийнхөө тухай ярина уу ? Гэсэн асуултын үр дүнг график 53 харна уу.




- ✚ Архинаас гарах – 10%
- ✚ Орон гэртэй болох – 11%
- ✚ Ажилтай болох – 14%
- ✚ Хүн шиг сайхан амьдрах – 63%
- ✚ Мэдэхгүй – 2%

ДҮГНЭЛТ

Судалгааны үр дүнгээс үндэслэн дүгнэхэд судалгаанд оролцогчдын: / Сэтгэл зүйн – СЗ/




Судалгаанд оролцогчид сэтгэл зүйн хувьд: 72,2% нь ээжийнхээ хөхийг хөхөж өссөн, 46% нь төрсөн аав ээж дээрээ өссөн, 56% нь хүүхэд насандаа сэтгэл зүйн цочрол авсан, 13% нь амиа хорлох оролдлого хийсэн, 77% нь хааяа үхлийн тухай боддог, 71% нь ганцаардал гэсэн сэтгэл зүйн тулгамдсан асуудалтай энэхүү асуудал нь 10-аас дээш жил үргэлжилж байна. Эмэгтэйчүүдийн хувьд 45% нь үр хөндүүлсэн, 45% нь үр зулбаж байсан. Ганцаардлын шалтгаан нөхцлийг судалвал 77% нь гэр бүл салалтаас үүдэлтэй ба гэр бүл салалтын 49% нь гэр бүлээс гадуурх харилцаа гэж хариулсан ба салсан гэр бүлийн 58% нь 11-ээс дээш жил хамт амьдарсан, хосууд хоорондоо харилцааны зөрчил үүсэхэд гэрээсээ гараад явчихдаг – 24%, дуугаа хураачихдаг – 40% байна.




Мөн 80% нь ажилгүй, 29% нь ял эдэлсэн / хулгай дээрэм- 42,4%, танхай – 45,4%/ , 83% нь бүрэн дундаас дээш боловсролтой, 70% нь ямар нэгэн мэргэжилтэй, 65% нь гэр оронгүй, орон гэргүй болсон шалтгаан: Зарсан – 20%, гэр бүлдээ үлдээсэн – 77%, шатсан – 3%


Гадуур амьдарч буй шалтгаан нөхцлийг авч үзвэл: Гэр оронгүй – 28%, архины хамаарал – 14%, ганцаардал сэтгэл зүйн асуудал – 58%




Согтууруулах ундааны хэрэглээний хувьд: 89% нь архи уудаг, архи ууж буй шалтгаан нөхцлийг авч үзэхэд сэтгэл зүйн шалтгаантай ба тодруулвал гэр бүл салалт - ганцаардлын асуудал зонхилж байна. Архи ууж буй хугацааны хувьд 47% нь 10-аас дээш жил, 5-10 жил - 14%, 2-5 жил - 24%, давтамж нь 55% нь өдөр бүр, 3-7 хоногт – 21%, 44% нь архины эмчилгээнд 1-4 удаа хамрагдсан байна.




Эрүүл мэндийн хувьд: 50% нь архаг хууч өвчтэй, 51% нь аваар осолд өртөж байсан, 22% нь хөгжлийн бэрхшээлтэй, 23% нь сүрьеэ өвчин туссан, 10% нь ковид -19 халдвар авсан.



Хүсэл мөрөөдөл: Архинаас гарах – 10%, орон гэртэй болох – 11%, ажилтай болох – 14%, хүн шиг сайхан амьдрах- 63%, мэдэхгүй – 2%



Сүүлийн 6 жилийн төвөөс байрлах үйлчилгээ авсан болон шинээр бүртгэгдсэн иргэдийн судалгаа



Судалгаанд оролцогчид харьцангуй төрсөн эцэг эх дээрээ өссөн, талаас илүү хувь нь хүүхэд насандаа сэтгэл зүйн гэмтэл авсан, хүүхэд насандаа бусдын адил өсөөд бүрэн дундаас дээш боловсрол эзэмшисэн. Харин нас бие хүрээд гэр бүлийн амьдралруу ороход гэр бүлийн боловсрол тааруу, мөн хүүхэд насны сэтгэл зүйн гэмтэл, харилцааны зөрчил гарахад асуудлаасаа зугтдаг шийдвэрлэхгүй байх, нууц амрагийн харилцаа үүсгэх зэрэг асуудлуудаас болж гэр бүлээсээ салсан байна. Гэр бүлээсээ салсан, хань нь нас барж, мөн хайртай хүмүүсээ алдах нь тэдэнд сэтгэл зүйн хүнд цочрол болж ганцаардлаа даван туулах арга замаа мэдэхгүй зовлон бэрхшээлээ мартагчид тулд архи согтууруулах ундаа удаан хугацаанд хэрэглэн архины хамааралтай болж гадуур амьдарч байгаа зэрэг үндсэн шалтгаанууд болж байна. Тэд ар гэр, төрсөн ах дүү төрөл садангийнхаа итгэлийг удаа дараа алдсанаас болж ах дүү хамаатан садан нь харилцаа холбоо тогтоохоос зайлсхийдэг, иргэд ч өөрсдөө тэднийхээ амьдралд төвөг удахыг хүсдэггүй байна. Мөн тэд орц, хонгилоор хоноглож, амь зуухын тулд шил лааз түүж амжиргаагаа залгуулж зөвхөн өнөөдрөөрөө амьдарч байна. Архины хамаарал, орон гэргүй байдлаасаа болж ажил хийдэггүй, нийгэм ч тэднийг архичин, тэнэмэл, нийгмийн хог шаар гэж үздэг. **Тэдний 10% нь л архинаас гарах хүсэлтэй дийлэнх хувь нь архи ууж гадуур тэнэн амьдарч байгаагаа асуудал гэж харж чадахгүй байгаа нь харамсалтай.** Хүсэл мөрөөдөл амьдралын зорилго үнэт зүйл, өөртөө итгэх итгэл өөрийн үнэлэмж, эрүүл мэнд, гэр

бүл нь аль хэдийн алдагджээ. Манай түр хоноглох байрны үйлчилгээ авч байсан иргэд 2015 онд 157, 2020 онд 627 буюу 4,2 дахин өссөн, шинээр бүртгэгдсэн иргэн 2015 онд 157, 2020 онд 326 иргэн бүртгэгдэж даруй 2 дахин өссөн тоон мэдээ байна.

1. Архины хамааралтай, орон гэргүй, тэнэмэл иргэд жилээс жилд өсөж байгаа тул дүүрэг, хороотой хамтран төсөл хөтөлбөр хэрэгжүүлэн эрсдэл бүхий иргэдэд анхаарлаа хандуулж урьдчилан сэргийлэх ажлуудыг зохион байгуулах
2. Нийгэм олон нийтэд хандсан сэтгэл зүйн болон гэр бүлийн боловсрол дээшлүүлэх контент хийх
3. Эдгээр иргэдтэй ажиллах сэтгэл зүйн болон нийгмийн ажлын гарын авлага гаргаж тусгайлсан оновчтой цогц хөтөлбөрийг хэрэгжүүлэн тэдний гэр бүл болон сэтгэл зүйн боловсролыг дээшлүүлж сэтгэцийн эрүүл мэнд, эрүүл мэнд, нийгмийн ажлын урт хугацааны үйлчилгээ үзүүлэх шаардлагатай хэмээн дүгнэж байна.

ХЯНАСАН: АХЛАХ АРГА ЗҮЙЧ
СУДАЛГААГ АВЧ НЭГТГЭН ДҮГНЭСЭН :
СЭТГЭЛ ЗҮЙЧ

Н.НЭРГҮЙ
Б.БУЯНСҮРЭН